

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Г. Цэндсүрэн	Дугаар	1181
Оршин суугаа аймаг	Говь-Алтай аймаг	Оршин суугаа сум	Эрдэнэ
Төрсөн газар	Эрдэнэ сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сангийн далайн хүрээ	Сүм хийдийн дугаар	ГАЭР 099
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 23	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Сангийн далайн хүрээ

2007 оны 8-р сарын 23-ны өдөр. Судалгааны бага Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын өндөр настан **Гэнэндармаагийн Цэндсүрэн** гуайтай уулзаад байна.

Асуулт: -Сангийн далай хүрээний түүхийг ярьж өгнө үү.

Хариулт: -Энэ ч одоо сайхан хийд л байсан юм даа, дугантай, мааниа хурчихдаг, **Майдар** эргэчихдэг, иш хөөрхий сайхан л шүтээн байсан юм. Энэ дуганыг хэлэхэд нь шинжээч хятадууд л шинжилж байгуулна гэж барьсан юм гэнэ лээ. Тэгээд би чинь эмэгтэй хүн болохоороо. Эрэгтэй хүн бол зөв л байна л даа. Одоо үгээ ярьж чадахгүй тийм болж хоцорсон л байна. Сайхан хийд байсан. 3 дуган байсан. Чойр жас, Цогчэн жас гээд. Тэгээд том лам нартай. Мааниа хурдаг, үрэл нь дэвэрдэг, янзын сайхан хийд л байсан юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Та энэ хийдийн том лам нараас нь мэдэж байна уу?

Хариулт:-Хэлмэгдээд баригдаад явсан. 3 том лам байсан. Нэрийг нь санахгүй болчих юм аа.

Асуулт:-Та **Майдарын** тухай ярьж өгөхгүй юу?

Хариулт:-Майдар чинь зун болгон эргэнэ. Тэгээд л морьтой. Хар морь байдаг юм. 8 сард билүү дээ болж байсан. **Майдар т** мөргөнө гээд бид нар чинь бага байлаа. Одоо удаан хэвтэж байгаад бодвол өчнөөн юм цээжинд ороод ирнэ.

Асуулт:-Та өөр хэлж ярих юм байвал сандралгүй бодож байгаад ярь даа.

Хариулт:-Хамгийн том лам нь ажаа Цорж гэж лам байсан, хамгийн сүүлд баригдаад явсан.

Асуулт:-37 оны үед баригдсан уу?

Хариулт:-Тийм.Хэдэн он байсан юм, би хуучнаар л ярьдаг юм. Тэр хүрээ тараад баригдаад тарж байхад гарсан хүн чинь 60 хэдтэй улсууд байна шүү дээ.

Асуулт:-Сүмийн дуганууд нь бүрэн бүтэн байхдаа ямархуу янзтай байв, та тэрнийг ярихгүй юу, ямархуу будаг шунхтай.

Хариулт:-Сайхан, зул сар зулын хурал болоод мөргөх гээд морьтой баруун хяр дээгүүр гараад ирэхэд гэгээ гэрэл гараад. 4 булан дээр нь 4 алтан **гөрөөс** байсан. 3 дуган байсан,сайхан л юм байсан. **Чойр** жас, **цогчэн** жас, **бурханых** гээд тийм нэртэй. Тэрнийг нь яаж мэдэж байгаа юм гэхээр **чойр** жасын малыг хариулсан, **Цогчэн** жасын малыг хариулсан улс хөдөөгүүр байдаг байсан.

Асуулт:-Үс ноосыг нь, идээ цагааг нь хийддээ өгөх үү?

Хариулт:-Тэгэлгүй **яахав**. Хурлаа хурна,идээ цагаа **сүүгий** нь. Мааниа хурна. Хамгийн сүүлд манай энд хулгана жил маани хурсан. Тэр хулгана жил чинь гарсан хулганатай хүн чинь тийм хүн байна уу, одоо байхгүй юм шиг байна. Мягмаржав хүрээнд сууж байсан тэр л сайн ярих бололтой. Манай хуучин төвийг чинь шинжээч хятадууд урд энэ судлаараа алт байгаа гэж үзсэн. Тэгээд л тэр хүрээг, тэр дугануудыг байгуулсан юм гэнэ лээ. Тэгээд ар луу малтаад, доогуур нь. Би одоо ярьдаг байхгүй юу. Дуганыг хоёрхон оньсыг мултлахаар, хадаас ерөөсөө байхгүй гэж байгаа.

Асуулт:-Монголчууд барьсан юмуу?

Хариулт:-Манайх өөрөө барьсан юм гэнэ лээ. Хадаас байхгүй, хоёрхон оньс мултрахад л унана гэсэн юм гэнэ лээ, тэгээд сүүлд нь манайхан чинь дотор нь гахайгаа хийгээд, малаа нядлаад, сүүлийн бүлэгт буулгасан даа.